12	646291.115	5308271.106	12-1=128.54

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХЭГЖЛИЙН ГАЗАР
Хот төлөвлөлтийн хэлтэс

Нийслэ
Утас: 11-324973, website: http://mpa.ub.gov.mn

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗӨВШӨӨРӨЛ АВАХ, БАРЬЖ БАЙГУУЛАХ ҮЕ ШАТ

- Хүсэлт гаргах /нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд/
- Үндэслэл бүхий хариуг ажлын 7 хоногт багтаан албан бичгээр хүргүүлэх
- Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх
- Хурлын шийдвэрийн дагуу зураг төсөл зохиох даалгавар боловсруулж Ерөнхий архитектороор батлуулна
- Батлагдсан зураг төсөл зохиох даалгаварыг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан хүсэлт гаргагчид өгнө

- Тухайн байгууламжийн зураг төслийг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага загвар зураг төслийг зохионо
- Загвар зургийг батлуулах хүсэлт Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХТЕТГазарт гаргана
- Холбогдох инженерийн шугам сүлжээний байгууллагуудаас техникийн нөхцөл авна
- Ажлын зураг төслийг боловсруулж холбогдох байгууллагуудтай зөвшилцөх
- Ажлын зураг төсөлд магадлал хийлгэх

- Барилга, байгууламжийн тэг тэнхлэгийг газарт шилжүүлсэн акт хийлгэж хот байгуулалтын мэдээллийн санд бүртгүүлнэ
- Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх хүсэлтийг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХТЕТГазарт гаргах
- Олгогдсон зөвшөөрлийн хүрээнд барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх
- Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлтийг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан НХТЕТГазарт гаргах
- Барилга, байгууламжийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх

ХАВСРАЛТ-1

БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ЗАМ, ТЭЭВРИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨСЛҮҮДИЙН УДИРДАГЧ

Б.ОДСҮРЭН

ЦАГААНХУАРАН ХОТХОНООС АХМАДЫН ХОРООЛЛЫН ЗҮҮН ТАЛЫН ДАЛАН ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Дугаар: ЗБ-А32/2021/030

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	-Нийслэлийн Засаг даргын 2021 оны 06 сарын 30-ны өдрийн А/523 тоот захирамж, холбоос зам,зүүн хэсэг
2	Байршил	Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Нийслэлийн төсвийн хөрөнгө
4	Авто замын техникийн ангилал, замын зэрэг	Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам.
5	Газрын бартаалаг, төвөгшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНбД-ээс харах
6	Замын хучилтын хийц	Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ
7	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2021 он
8	Зураг төслийн байгууллага	Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага
9	Захиалагч байгууллага	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
10	Зураг төслийн иж бүрдэл	1. Инженер геодезийн ажлын тайлан 2. Инженер геологийн судалгааны ажлын тайлан 3. Авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл 4. Тайлбар бичиг (хучилтын тооцоо, ус зүйн тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, авто замын зураг төслийн бүрдэл, холбогдох захирамж, техникийн нөхцөл, магадлалын дүгнэлт гэх мэт) 5. Техникийн шаардлага 6. Холбогдох шугам сүлжээний зураг төсөл, төсөв 7. Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв 8. Төслийн танилцуулга

11. Онцгой нөхцөл:

- Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНбД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31.101.04, "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНбД 32-02-12, "Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага" MNS 6808:2019, "Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний

ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам" болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх

- Геодезийн хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, зам барилгын суурь бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх тулгуур цэг байгуулах, замын төлөвлөлтийн дагуу өндрийн болон байрлалын хэмжилт хийж баталгаажуулж газрын хар өндрийг тодорхойлох
- Байр зүйн болон өндрийн хэмжилтийг UTM системд хийх
- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага, Улаанбаатар хотын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан зураг төслийг боловсруулах
- Трасс сонголтыг газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, инженерийн шугам сүлжээ, одоо байгаа барилга байгууламж, хэтийн хөдөлгөөний эрчмийг анхаарч үзнэ,
- Гудамж замын төлөвлөлттийн талаар танилцуулга, мэдээллийг тайлбар бичигт тусгах, захиалагч байгууллагад урьдчилан танилцуулах.
- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох.
- Хөрсний шинж чанараас шалтгаалан замын суурийг оновчтой сонгох
- Авто замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, гүүр хоолой, унадаг дугуйн зам /*төслөөр*/, уулзвар төлөвлөлт, гэрлэн дохио, нийтийн тээвэр болон автомашины зогсоол, явган хүний гарц /нэг болон хоёр түвшин гарцыг төслөөр/, ногоон байгууламж, тусгаарлах зурвас, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх, план зураг инженерийн шугам сүлжээний өөрчлөлт газрын нөлөөлөл, орчны мэдээллийг нэгтгэн боловсруулж үзүүлсэн байна.
- Явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн өнгө төрхийг тухайн орчны харагдах нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх. Хот байгуулалт, хөгжлийн газраас санал авах.
- Хөндлөн огтлолыг орчны нөхцөлтэй уялдуудан төлөвлөх, барилга байгууламж, айлууд руу орох орц гарцны шийдлийг оновчтой хийж хөндлөн огтлолыг төлөвлөх
- Гадаргуугийн ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлуулах байгууламжийг цогцоор нь шийдэх. Геодези Усны Барилга Байгууламж ОНӨААТҮГ-тай зураг төслийг зөвшилцөх
- Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцөлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагатай зөвшилцөх, ажлын зургийг батлуулах
- Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах
- Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх. Замын Хөдөлгөөний Удирдлагын төвтэй зөвшилцөх
- Авто замын трассад орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эзэлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх

- Авто замын гэрэлтүүлгийг төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК руу бие даан хандаж /өргөдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийг боловсруулах.
- Авто замын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан "LED" технологиор шийдвэрлэх
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:

Дэвсгэр зураг		1:500
Дагуу огтлол	хэвтээ	1:1000
	босоо	1:100
Хөндлөн огтлол		1:100
Уулзвар, огтлолцол		1:500
Бүтээц		1:20

- Авто зам төлөвлөлтийн шатанд буюу авто замын план зургийг Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Нийслэлийн Газар Зохион Байгуулалтын Алба, Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-тай тус тус зөвшилцсөний үндсэн дээр нарийвчилсан зураг төсөлд холбогдох газруудаас санал аван зураг төслийг баталгаажуулах.
- Тухайн зам, замын байгууламжийн үндсэн элементүүдийг нийслэлийн авто замын бүртгэл мэдээллийн сангийн бүтэц бүрэлдэхүүний дагуу мэдээллийг боловсруулж цахим хэлбэрт замын шинж чанарын мэдээллийг үүсгэж "хотын замын мэдээллийн сан"-д оруулах, баталгаажуулах /хавсралтын дагуу боловсруулах/
- Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг Хот байгуулалт, Хөгжлийн газрын "ТООН ЗУРГИЙН ТАНИХ ТЭМДЭГ"-ийн дагуу боловсруулсан байна.
- Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 2ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө.

ЗӨВШӨӨРСӨН:
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР БӨГӨӨД ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА Ц.ТУЛГА

НАЗХГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.БАЯРСАЙХАН

ХЯНАСАН:
ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА С.ДАЛАНЖАРГАЛ

НАЗХГ-ЫН БОДЛОГЫН, ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ О.ЭНХБААТАР

БОЛОВСРУУЛСАН:
ХОТ БАЙГУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.ТҮМЭН-ОД

НАЗХГ-ЫН БОДЛОГЫН, ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН А.ОЮУНЧИМЭГ

2021 оны 07 сарын 07-ны өдөр

УБЦТС ТӨХК

ЗУРАГ ТӨСӨЛД ТОДРУУЛГА ХИЙСЭН ТОДОРХОЙЛОЛТ

20.21.оны.10.сарын..11.. №

Зураг төслийн захиалагч, объектийн байршил: БЗД. 14р хороо, Цагаанхуаран хотхоноос ахмадын хорооллын зүүн талын далан хүртэлх автозамын зураг.

Зураг төслийн гүйцэтгэгч: "Х.Ар Ти Инженер Консалтинг Монгол" ХХК

Зураг төслийн дугаар нэр:.....

Зураг төсөлд хийсэн тодруулга:

А.Ойртож байгаа болон Огтлолцож байгаа цахилгаан дамжуулах кабель шугам

1р хөт: ХТП-3081 ÷ ХТП-2391, РП-29 хооронд 10кВ КШ - 2ш

2р хөт: ХТП-3081 ÷ ХТП-4731 хооронд 10кВ КШ - 1ш

3р хөт: ХТП-2391 ÷ өгөөмөр хотхон 0,4кВ КШ - 2ш

4р хөт: ХТП-2391 ÷ Норт хотхон 0,4кВ КШ - 2ш

5р хөт: ХТП-4731 ÷ Норт хотхон 0,4кВ КШ - 2ш

6р хөт: ХТП-4731 ÷ Норт хотхон 0,4кВ КШ - 2ш

7р хөт: Хүүрэн түр №5-с ХТП-4731 хооронд 10кВ КШ - 1ш

8р хөт: Хүүрэн түр №40,5,6 хооронд 10кВ АШ - 1ш

– Газар шороонд ажил хөдөлгөхгүй өмнө газар дэрсэн кабель гаргуулах!

.....тус тус огтолж, давхцаж байна. "УБЦТС ТӨХК" **Техникийн бодлого шинэчлэлтийн хэлтэстэй** зөвшилцөн холбогдох зөвшөөрлийг авсаны дараа газар шорооны ажлыг гүйцэтгэх. Аливаа **ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫГ** эхлэхээс өмнө **ЗҮҮН ТҮГЭЭХ ТӨВӨӨР** газар дээр нь дахин тодруулга хийлгэн хяналтанд ажлыг гүйцэтгэх шаардлагатайг анхаар !!!.

Жич:Бусад иргэн, хуулийн этгээдийн шугам сүлжээг тухайн эзэмшигчтэй зөвшилцөх шаардагатай.

Тодруулга хийсэн:

Мэдээллийн сангийн инженер / Я.Мөнхбат /

Цахилгаан дамжуулах кабель шугамын трассын тодруулга хийлгэсэн хэрэглэгчдэд өгөх зөвлөмж

- Кабель шугамаас 2 тийш 2м босоо хавтгайгаар хязгаарлагдах бүсэд машин, механизм хэрэглэхийг хориглоно. Кабель шугамыг ЗТТ-ийн ажилтны хяналтан дор гараар ухаж ил гаргана.
- Газар доор байгаа хамгийн захын кабель шугамаас 2 тийш 5м босоо хавтгайгаар хязгаарлагдах бүсэд цохилтот машин, механизм хэрэглэхийг хориглоно.
- Кабель шугамын трассыг чагнуулж энэхүү хуудсыг авсанаас хойш 30 хоногт газар шорооны ажил хийгээгүй бол дахин тандалт хийлгэх
- Хэмжилт хийж кабель шугамтай гэж тодорхойлсон цэгт кабель шугам илрээгүй тохиолдолд, мөн тусгагдаагүй кабель шугам илэрсэн үед хэмжилт хийлгэсэн техникчтэй эргэж холбоо барин дахин тодорхойлуулна.
- Кабель хайгч багажны мэдрэх чадвараас шалтгаалан заасан цэгт дулаан, цэвэр болон бохир усны труба, холбооны кабель шугам гарч болохоос гадна хүчдэлтэй болон хүчдэлгүй кабель шугам аль аль нь хамтдаа мэдрэгдэх тул анхаарах
- Санамсаргүй тохиолдлоор кабель шугамыг ил гаргасан буюу гэмтээсэн тохиолдолд кабель шугамыг тодорхойлсон инженертэй нэн яаралтай холбоо барих
- Газар шорооны ажил хийж байхдаа кабель шугамыг ил гаргасан буюу гэмтээсэн тохиолдолд кабель шугамыг тодорхойлсон ажилтантай нэн яаралтай холбоо барих
- Газар шорооны ажил хийж байхдаа кабель шугамыг гэмтээсэн тохиолдолд тухайн кабель гэмтээд зогсохгүй бусад тоног төхөөрөмж гэмтэх, хэрэглэгчдийн цахилгаан хэрэгсэл шатах зэрэг ноцтой зөрчилүүд үүсэх бөгөөд гарсан төлбөрийг буруутай байгууллага ААНэгж, иргэн хариуцна.
- Гадны ашиглалтын шугам сүлжээг / Авто замын гэрэл, цахилгаан тээвэр компани, Улаанбаатар төмөр зам / ашиглагч байгууллагаас авах
- Кабелийн тандалт хийсэн талбайд тодорхойлогдоогүй ЦДКШ гарч ирвэл ГША-ыг зогсоож ашиглагч байгууллагатай зөвшилцөж шийдвэр гарсны дараа ГША-г үргэлжлүүлнэ.

ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ АЖИЛЛАНА УУ!!! БИДЭНТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТАНД БАЯРЛАЛАА


БАЙРШЛЫН ТОЙМ ЗУРАГ М1:2000
ЗӨВШӨӨРӨГДӨХ ТАЙЛБАР
Д/Д
ТОДОРХОЙЛОЛТ
ТАЙЛБАР
1 Обор байгаа обьект зам Ашиглагдах байгаа
2 Төлөвлөх бүй обьект зам /2 эгнээ, 6 метр/ Төлөвлөх бүй
3 Төлөвлөх бүй нөөцөөр бүрэлдэхүүнтэй /16 метр/ Төлөвлөх бүй
4 Төлөвлөх бүй явган зам /15 метр/ Төлөвлөх бүй
5 Төлөвлөх бүй зорчих хэсэг / 0.5 метр/ Төлөвлөх бүй
6 Төлөвлөх бүй тоосжилтыг тоолбой / 200 мм/ Төлөвлөх бүй
ТРАСС-1 ЗҮҮН
ТРАСС-2 ЗҮҮН
ТРАСС-2 ТӨВ
ТАНИХ ТЭМДЭГ
SRP
УБ. ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 14 ДҮГЭЭР ХОРОО, ЦАГААНХУАРАН ХОТХОНООС АХМАДЫН ХОРООЛЛЫН ЗҮҮН ТАЛЫН ДАЛАН ХҮРТЭЭХ АВТО ЗАМЫН ТӨВӨЛ
ДЭВСГЭР ЗУРАГ ЗӨВШӨӨРӨГДӨХ
Зураг зурсан: Г.Чимэдсүрэн
Зураг шалгасан: Т.Гүнжидсүрэн
Б.Бүүдэн-Эрдэнэ
Т.Гүнжидсүрэн
Масштаб 1:750
Зураг зурсан огноо 04/21
2021 он 9 сар

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ТӨВ НӨҮГ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Бага тойруу 15,
Нийслэлийн засаг захиргааны IV байр, 15160-0056
Утас: 7011-1642, Факс: 7011-1640
E-mail: info@ubtraffic.mn
http://www.ubtraffic.mn

2021.11.10 № 03/909
танай 2021.10.22-ны № 01/296-т

"ЭС АР ПИ" ХХК-Д

Танай боловсруулсан Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, Цагаанхуаран хотхоноос Ахмадын хороллын зүүн талын далан хүртэлх зам, 13 дугаар хороо, Сүнжин Грандаас урагш гэр хороолол дундуур нарны зам хүртэлх авто замын зураг төслүүдийг судлан үзээд дараах саналыг хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

УЛААНБААТАР ХОТ
ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ТӨВ НӨҮГ
ТТГ5032 ☎ 5379105

ОРЛОГЧ ДАРГА Л.БАТЦООЖ

01-32 Явуулсан Бичгийн Төсөл\11-12 Сар\А5.Docx
215041537

ХАВСРАЛТ

1. Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, Цагаанхуаран хотхоноос Ахмадын хорооллын зүүн талын далан хүртэлх зам:
   - Төлөвлөж буй трасс дахь хөдөлгөөн зохион байгуулалтын зураг дээрх авто замын тэмдэглэлийг стандартын дагуу дахин төлөвлөх.
   - Төлөвлөж буй трассын эхлэлд байрлах 7.13 Гол замын чиг нэмэлт тэмдгийн гол замыг заасан чигийг зөв болгох.
   - Төлөвлөж буй трассын нэг чигийн эхлэл болон төгсгөлд 5.7 Нэг чигийн хөдөлгөөн, 5.8 Нэг чигийн хөдөлгөөний төгсгөл мэдээлэх тэмдгүүдийг мөн 2.1 Орох хориотой хориглох тэмдгүүдийг төлөвлөх.
   - Нэг чигийн хөдөлгөөний зохион байгуулалттай замтай нийлж буй автограшийн орох гарах хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан толь байршуулах.
   - Нэг чигийн хөдөлгөөнтэй нийлж буй авто зогсоол болон гарцны хэсэгт 5.9а болон 5.9б мэдээлэх тэмдэг байршуулах.
   - Нэг чигийн хөдөлгөөн зохион байгуулалттай зорчих хэсгийн өргөнийг 3м-3,5м өргөнтэй төлөвлөж дагуу зогсоол төлөвлөх.
   - Төлөвлөж буй трассын ПК0+280 орчимд төлөвлөсөн 4.1.б Баруун гар тийш явна тэмдэг нь далангийн замтай холбогдох хэсэгт байрлаж байгаа бол тавих шаардлагагүй.
2. Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо, Сүнжин Грандаас урагш гэр хороолол дундуур нарны зам хүртэлх авто замын зураг:
   - Төлөвлөж буй трассын нэг чигийн эхлэл болон төгсгөлд 5.7 Нэг чигийн хөдөлгөөн, 5.8 Нэг чигийн хөдөлгөөний төгсгөл мэдээлэх тэмдгүүдийг мөн 2.1 Орох хориотой хориглох тэмдгүүдийг төлөвлөх.
   - Нэг чигийн хөдөлгөөнтэй нийлж буй авто зогсоол болон гарцны хэсэгт 5.9а болон 5.9б мэдээлэх тэмдэг байршуулах
   - ПК0+240-ээс ПК0+280 орчимд хөдөлгөөний дараалал тогтоож дахин төлөвлөх.
   - ПК0+380 хэсэгт төлөвлөж буй явган хүний гарцыг явган замтай холбох, явган замыг мухардуулахгүй явган хүний гарц орцтой холбох.

Мөн төлөвлөж буй 2 зургийн нарийвчилсан зураг теслийг гүйцэт төлөвлөсний дараа дахин зөвшилцөнө үү.

УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
16030 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
Ф.Энгельсийн гудамж, Утас/Факс: (976-11) 34 23 97,
И-мэйл: dhsub@ubds.energy.mn

2021.10.11 № 11/1970
танай 2021.10.06-ны № 01/258-т

ЭС АР ПИ ИНЖЕНЕР КОНСАЛТИНГ
МОНГОЛИА ХХК-Д

Танай компани нь Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо Цагаанхуаран хотхоноос Ахмадын хорооллын зүүн талын далан хүртэлх гудамж, авто замын зураг төслийн ажлын (НХААГ-21/162) дугаартай гэрээ байгуулж, ЗД-БЗД/2021/030 дугаар бүхий зураг төсөл боловсруулан дулааны шугамын тодруулга хүссэн байна.

Тус шугамын трассад "УБДС" ТӨХК-ийн эзэмшил дулааны шугам байхгүй бөгөөд компанийн тодруулга зурагт бүртгэгдсэн Грийн ресорт хотхоны (Монтс ХХК) 2Ø150мм, Зүмбэр орд ХХК-ийн 2Ø150мм голчтой хэрэглэгчийн салаа шугамын трасс давхацсан бусад хэрэглэгчийн дундын шугам, иргэн Янжмаагийн амины орон сууцны салаа шугам хөндлөн гарсан байгаа тул тус байгууллагуудтай зөвшилцөн сувгийг хүчитгэх шаардлагатай.

УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ДУЛААНЫ ТӨХК
2688476

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАЯРСАЙХАН

3160603338

БАТЛАВ
УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ДАГДАН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 15/05200/21

2021 оны 10 сарын 26 өдөр Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	**Хүсэлтийн дугаар:**	*21-52-001862*
1.2	**Хэрэглэгчийн нэр, регистр:**	*НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР /ЭС АР ПИ ИНЖЕНЕР КОНСАЛТИНГ МОНГОЛИА ХХК/ Төрийн байгууллага - РД: 5540798,*
1.3	**Хэрэглэгчийн байршил:**	*Улаанбаатар Баянзүрх 13-р хороо, 13, 14-р хороо*
1.4	**Ажил үйлчилгээний зориулалт:**	*Авто зам*
1.5	**Техникийн нөхцөл олгох үндэслэл:**	*1) Автозамын хөгжлийн газрын 2021 оны 3/1875 дугаартай албан бичиг*
1.6	**Техникийн нөхцөлийн ангилал:**	*Шинэ холболт*
1.7	**Тооцооны бүрэн чадал:**	*6 кВА (тоогоор)* */Зургаа/ (үсгээр)*

Хоёр. Холболтын цэг:

2.1	35/10 кВ-ын Дорнод-1 дэд станцын 10 кВ-ын Дүүрэг фидерийн ХТП-4731 дэд өртөөний 0.4 кВ талд 10 А-ийн дтфференциал автомат бүхий групп тоноглож кабель шугам татаж гэрэлтүүлгийн салбарыг тэжээх.

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Гэрэлтүүлгийн 0.4 кВ-ын щитнүүдэд ачаалалд тохирсон дифференциал автомат болон хамгаалан таслах төхөөрөмж / УЗО/ суурилуулах, DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон, 100 А-ийн тоолуур суурилуулах.

Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
4.2	УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцад хийгдэх өргөтгөлийн ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.
4.3	Барилгын талбайд орсон УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн бус тоноглолын талаар эзэмшигчээс зөвшөөрөл авах.
4.4	Олгогдсон 6 кВА тооцооны бүрэн чадлыг хэтрүүлэн хэрэглэсэн нь нотлогдвол техникийн нөхцөлийг цуцлах болно.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

5.1	Шугамын "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар

https://new.tog.mn/#/admin/request/21-52-001862 1 / 2

	хянуулах.
5.2	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"- ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх.
5.3	Хүсэлт гаргагч нь хэрэглэх чадалдаа тохируулж чадлын хязгаарлагчийг суурилуулах. Техникийн тодорхойлолтыг Техникийн бодлого зохицуулалтын хэлтсээс авах.
5.4	Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
5.5	Засгийн газрын 2020 оны 97 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг мөрдлөг болгох.
5.6	"Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9, 30.1.10-ийн дагуу өөрийн тоноглолоос тус компанийн зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах.
5.7	"Эрчим хүчний тухай" хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
5.8	Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
5.9	Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
5.10	Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад:

6.1	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.

Комиссын гишүүд: Л.Ганзориг

Б.Аззаяа

Т.Мөнхболд

А.Зоригт

Боловсруулсан: П.Дуламжав

БАТЛАВ
УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ДАГДАН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 15/05359/21

2021 оны 10 сарын 29 өдөр Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	**Хүсэлтийн дугаар:**	*21-52-001863*
1.2	**Хэрэглэгчийн нэр, регистр:**	*НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР /ЭС АР ПИ ИНЖЕНЕР КОНСАЛТИНГ МОНГОЛИА ХХК/ Төрийн байгууллага - РД: 5540798,*
1.3	**Хэрэглэгчийн байршил:**	*Улаанбаатар Баянзүрх 13-р хороо, 14-р хороо*
1.4	**Ажил үйлчилгээний зориулалт:**	*Шугам, дэд станц зөөх*
1.5	**Техникийн нөхцөл олгох үндэслэл:**	*1) Автозамын хөгжлийн газрын 2021 оны 3/1875 дугаартай албан бичиг* *2) УБЦТС ТӨХК-ийн ЗТТ-ийн 2021 оны зураг төсөлд тодруулга хийсэн тодорхойлолт /14-р хороонд-1, 13-р хороонд-2/*
1.6	**Техникийн нөхцөлийн ангилал:**	*Цахилгаан дамжуулах шугам, дэд станц зөөх*
1.7	**Тооцооны бүрэн чадал:**	*(тоогоор)* *(үсгээр)*

Хоёр. Холболтын цэг:

2.1	Энэхүү техникийн нөхцөлийн тусгай заалтад тусгагдсан цахилгаан дамжуулах шугамыг батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн шилжүүлэн зөөх.

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	

Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Төлөвлөж байгаа замын хэсэгт дараах агаарын болон кабель шугам, тулгуурууд, дэд өртөө нь авто замын трассад давхацсан, зам хөндлөн гарсан, ойртсон байгаа тул батлагдсан зургийн дагуу трасс өөрчлөн зөөх Үүнд: 4.1.1) 10 кВ-ын кабель шугамууд: /БЗД-ийн 14-р хороонд/: - Хуваарилах байгууламж №29-өөс ХТП-3081 дэд өртөө хоорондох 10 кВ-ын 2 ширхэг кабель шугам автозамын трасст орсон - ХТП-3081 дэд өртөөнөөс ХТП-4731 хоорондох 10 кВ-ын 1 ширхэг кабель шугам автозамын трасст орсон - Дүүрэг фидерийн тулгуур №5-аас ХТП-4731 хоорондох 10 кВ-ын 1 ширхэг кабель шугам автозамын трасст орсон /БЗД-ийн 13-р хороонд/: - ХТП-925 дэд өртөөнөөс ХТП-2083 хоорондох 10 кВ-ын 2 ширхэг кабель шугам автозамын трасст орсон

https://new.tog.mn/#/admin/request/21-52-001863 1 / 3

	- ХТП-1451 дэд өртөнөөс ХТП-3560 хоорондох 10 кВ-ын 1 ширхэг кабель шугам автозамын трасст орсон - Дүүрэг фидерийн тулгуур №28-аас ХТП-5001 хоорондох 10 кВ-ын 1 ширхэг кабель шугам автозамын трасст орсон - Дүүрэг фидерийн тулгуур №33-аас КТПН-1450 хоорондох 10 кВ-ын 1 ширхэг кабель шугам автозамын трасст орсон - Чулуун-Овоо фидерийн тулгуур №24-аас ХТП-1228 хоорондох 10 кВ-ын 1 ширхэг кабель шугам автозамын трасст орсон тул дээрх кабель шугамуудыг батлдагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн шилжүүлэн зөөх 4.1.2) 10 кВ-ын агаарын шугам: /БЗД-ийн 13, 14-р хороонд/: - 10 кВ-ын Дүүрэг фидерийн тулгуур №40, 5, 6 хоорондох 10 кВ-ын агаарын шугам, тулгуурууд автозамын трасст орсон - 10 кВ-ын Дүүрэг фидерийн тулгуур №27-29 хоорондох 10 кВ-ын агаарын шугам, тулгуурууд автозамын трасст орсон тул эдгээр шугамуудыг батлагдсан зураг төслийн дагуу агаарын шугамаар трасс өөрчлөн шилжүүлэн зөөх 4.1.3) -0,4 кВ-ын кабель шугам: - ХТП-2391 дэд өртөнөөс Өгөөмөр хотхон хоорондох 0.4 кВ-ын 2 ширхэг кабель шугам автозамын трасст орсон - ХТП-2391 дэд өртөнөөс Нарт хотхон хоорондох 0.4 кВ-ын 2 ширхэг кабель шугам автозамын трасст орсон - ХТП-4731 дэд өртөнөөс Нарт хотхон хоорондох 0.4 кВ-ын 2 ширхэг кабель шугам автозамын трасст орсон /5-р цэгт/ - ХТП-4731 дэд өртөнөөс Нарт хотхон хоорондох 0.4 кВ-ын 2 ширхэг кабель шугам автозамын трасст орсон /6-р цэгт/ тул батлдагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн шилжүүлэн зөөх
4.2	Цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугамын зөөх байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн Нийслэлийн барилга, хот байгуулалт төлөвлөлтийн газраар батлуулж, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
4.3	Цахилгаан дамжуулах агаарын шугамыг кабель шугамаар трасс өөрчлөн зөөх бол 2 талдаа хуурай салгуур бүхий алсын удирдлагатай, УБЦТС ТӨХК-ийн СКАДА системтэй холбогдож ажилладаг реклоузерийн пункт суурилуулах. Реклоузерийн пункт суурилуулах байршлыг ажлын зураг төслийн шатанд тус компанитай зөвшилцөх.
4.4	Авто замын трассын уртын 50 метр тутамд зам хөндлөн ган хоолой суурилуулах. Суурилуулах ган хоолойны байршил, тоо хэмжээг зураг төслийн шатанд тус компанийн техникийн бодлогын хэлтэстэй зөвшилцөх.
4.5	Шинээр татах кабель шугам нь авто зам болон тохижилттой зам талбайгаар хөндлөн гарах тохиолдолд кабелийг ган хоолойнд сүвлэх ба тохижилттой зам талбайд авах боломжтой хавтан суурилуулах.
4.6	Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
4.7	Авто замын трасст орсон УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн бус цахилгаан дамжуулах шугам, тоноглолыг шилжүүлэн зөөх тохиолдолд эзэмшигчээс зөвшөөрөл авах ба бусад инженерийн байгууламж хариуцсан байгууллагуудтай зөвшилцсөн байх.
4.8	Шилжүүлэн зөөсөн болон шинэчилсэн цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам, тулгуур бусад тоноглолыг УБЦТС ТӨХК-ийн харьяа түгээх төвд актаар хүлээлгэн өгөх.
4.9	Буусан шугам, тоноглолыг УБЦТС ТӨХК-ийн харьяа түгээх төвд актаар хүлээлгэн өгөх.
4.10	Зөөж шилжүүлэх 10 кВ, 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын болон кабель